



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

“Үндэсний аялал жуулчлалын Улаанбаатур” үзэсгэлэнд оролцох тухай

Төсвийн тухай хуулийн 16.5, 16.5.2, Найрсаг Улаанбаатар хөтөлбөрийг 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.4.3, 2.6.4, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 3.2.4, 3.2.5, 4.6, 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Хот орчимд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих, дотоод, гадаадад аялагч нийслэлийн иргэдэд аяллын холбогдолтой бүх төрлийн зөвлөгөө, мэдээллийг нэг дороос хүргэх зорилгоор 6 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулагдах “Үндэсний аялал жуулчлалын Улаанбаатур үзэсгэлэн”-д оролцсугай.

2. Үндэсний аялал жуулчлалын Улаанбаатур үзэсгэлэнд оролцох удирдамжийг нэгдүгээр, шаардагдах зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Үзэсгэлэнд оролцоход шаардагдах төсөв болох 10,000,000 /арван сая/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

4. Үзэсгэлэнд удирдамжид заасны дагуу оролцож, үр дүнг тайлагнаж ажиллахыг Дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн /Н.Алтанзаяа/-д даалгасугай.


ДАРГА



Э.БАТТУЛГА

1150500183

Нийслэлийн аялал жуулчлалын газрын
даргын 2017 оны 06 сарын 18 өдрийн А/58
тоот тушаалын нэгдүгээр хавсралт



“ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН УЛААНБААТУР” ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦОХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

Сүүлийн жилүүдэд нийслэлийн иргэд хилийн чанадад аялах явдал эрс нэмэгдэж, аяллын төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллагууд олноор байгуулагдсан. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах, амралт зугаалгын улирал эхэлж байгаатай холбогдуулан нийслэлчүүдэд шинэ зорих газрууд, аяллын холбогдолтой бүх төрлийн зөвлөгөө, мэдээллийг нэг дороос хүргэх зорилгоор уг үзэсгэлэнд оролцоно.

Хоёр. Ерөнхий зохион байгуулагч:

Улаанбаатар аялал жуулчлалын холбоо

Гурав. Хамтран зохион байгуулагч, дэмжигч байгууллагууд:

Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
Нийслэлийн Аялал жуулчлалын газар

Дөрөв. Хугацаа, байршил:

2015 оны 06 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд
Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд

Тав. Хамрах хүрээ:

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын нэгдсэн зохион байгуулалтын дор оролцох байгууллагууд

- Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа гадаад орнуудын элчин сайдын яамд, дипломат төлөөлөгчийн газрууд
- Гадаад улс, харилцаат хотуудын соёлын төв, аялал жуулчлалын газрууд
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд
- Нийслэлийн өмчит байгууллагууд
- Найрсаг Улаанбаатар хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж буй төрийн бус байгууллагууд, аян хэрэгжүүлэгч, зохион байгуулагчид

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны нэгдсэн зохион байгуулалтын дор оролцох байгууллагууд

- Аймгуудын Байгаль орчин, ногоон хөгжлийн газрууд

- Улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа

Зургаа. Зохион байгуулагдах үйл ажиллагаа:


- Нийслэлийн иргэдэд зориулсан аялал, амралтын үзэсгэлэн
- Гадаад улс оронд аялах зөвлөгөө, мэдээлэл
- Аймаг орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээлэл
- Аялагч жуулчдад зориулсан сургалтууд

Долоо. Сургалтын хуваарь:

Доорх уулзалт, ярилцлагууд нь 6-р сарын 19, 20, 21-ний өдрүүдэд 12.00-16.00 цагийн хооронд үзэсгэлэнгийн танхимын зүүн урд байрлах 2 дугаар давхрын хурлын танхимд болно.

12.00- 12.20	“Зохион байгуулалттай аялалд хамрагдахын ач холбогдол” <i>Зочин илтгэгч Ч.Буянбадрах</i>
12.25- 12.45	“Дэлхий яагаад Говийг сонирхоно вэ?” <i>Зочин илтгэгч Х.Түмэндэлгэр</i>
12.50 - 13.10	“Дугуйн аялалд бэлтгэх нь” <i>Зочин илтгэгч С.Алдархишиг</i>
13.15 - 13.35	“Шувууны зураг авах, зургаа боловсруулах аргачлал” <i>Зочин илтгэгч Л.Жаргалсайхан</i>
13.40 - 14.00	“Хустайн байгалийн цогцолборт газарт аялах нь” <i>Зочин илтгэгч Ц.Дашпүрэв</i>
14.00 – 14.20	“Ослын үеийн анхны тусламж” <i>Зочин илтгэгч Б.Гантулга</i>
14.30 - 14.50	“Аяллын үед гэрэл зураг авах зөвлөмж” <i>Зочин илтгэгч Н.Бат-Эрдэнэ</i>
15.00 - 15.20	“Монголын гайхамшигт үлэг гүрвэл” <i>Зочин илтгэгч Б.Майнбаяр</i>
15.30 - 16.00	“Галбын говийн аялал” <i>Зочин илтгэгч Н.Банди</i>

Нийслэлийн аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 06 сарын 18 өдрийн ... 1158
тоот тушаалын хоёрдугаар хавсралт



**“ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН УЛААНБААТУР”
ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦОХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын нэгдсэн зохион байгуулалтын дор оролцох байгууллагуудын талбайн түрээс /3 хоног/	1	9,500,000	9,500,000
2	Хэвлэлийн зардал/фото стикер	12,5м ²	40,000	500.000
Дүн				10 000 000